



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Г Аудитын тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлж, холбогдох материалыг зохих журмын дагуу байгууллагын архивт хүлээлгэн өгч, аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /С.Энхбаатар/-т даалгасугай.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Л.Оюун-Эрдэнэ/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/ нарт зөвлөсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /С.Оюунбилэг/-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ



Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт.....	1
Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар	Хүснэгт, графикт мэдээллийн жагсаалт.....	1
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	2
С.Энхбаатар	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	2-3
Аудитын менежер Х.Болдбаатар	Үндсэн мэдээлэл.....	3-4
Ахлах аудитор Л.Нямтөмөр	БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ЭХ ҮҮСВЭР ТУС БҮРЭЭР БҮРДҮҮЛЭХ АЖИЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	5-9
Аудитор Ц.Цэрэннамжил Б.Чимэдлхам	1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна.....	5-7
Гэрээт аудитор Э.Хаш-Эрдэнэ	1.2. Зарим аймгууд ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө зөвхөн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгээр төлөвлөж бусад эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.....	7-8
2019 оны 5 дугаар сар	1.3. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг зарим аймгууд батлагдсан аргачлал, хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.....	8-9
Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү. www.audit.mn	БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ЧИГ ҮҮРГЭЭС БУСАД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	8-9
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.	2.1. Зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримталж ажиллаагүй байна.....	10-21
Хаяг: Үндэсний аудитын газар Засгийн газрын IY байр Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 15160 Монгол Улс	2.2. ОНХС-ийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ шаардлагыг хангах зардалд зарцуулж байна.....	10-14
	БҮЛЭГ 3. ТУХАЙН ШАТНЫ ДОТООД АУДИТЫН НЭГЖЭЭС ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙНХЭЭ ДАГУУ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ИТХ ДЭРГЭДЭЭ ХЯНАЛТЫН ХОРОО БАЙГУУЛАН ХЯНАЛТ ТАВИХ АЖИЛ ЖИГДРЭЭГҮЙ БАЙНА.....	14-21
	3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад зарим аймгууд хяналт тавьж ажиллаагүй байна.....	22-27
	3.2. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг зарим аймгууд холбогдох журам, зааврын дагуу тайлагнаж хүргүүлээгүй байна.....	22-24
	3.3. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.....	24-25
	Холбогдох байгууллагын санал	25-27
	Дүгнэлт	28
	Зөвлөмж	29
	Хавсралт.....	30
		31-35



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
БНД	Багануур дүүрэг
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗД	Засаг дарга
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ХТШ	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ЭЗХТ	Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэс
ЭМГ	Эрүүл мэндийн газар

ХҮСНЭГТ, ГРАФИКТ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1	ОНХНС-ийн 2018 оны эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл
ХҮСНЭГТ 2	ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг
ХҮСНЭГТ 3	ОНХНС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт
ХҮСНЭГТ 4	ОНХНС-аас 2018 онд ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл
ХҮСНЭГТ 5	Орон нутгийн хөгжлийн санд 2018 онд төвлөрсөн эх үүсвэр
ХҮСНЭГТ 6	ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тоон мэдээлэл
ХҮСНЭГТ 7	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьсан байдал
ХҮСНЭГТ 8	ОНХС-ийн 2013-2017 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчил
ГРАФИК 1	ОНХС-ийн эх үүсвэр төлөвлөлтийн 2017, 2018 оны харьцуулалт /хувиар/
ГРАФИК 2	ОНХС-ийн 2013-2018 оны хөрөнгийн эх үүсвэр, аудитаар илэрсэн зөрчлийн харьцуулалт



Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад ОНХНС, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2018 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналыг СЯ болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, ХОХБТХ, Баг, хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 400, 3000, 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан Сангийн яам, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоолоор баталсан *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”*;
- Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалаар баталсан *“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”*;
- Сангийн сайдын 2014 оны 3 дугаар 6-ны өдрийн 43 дугаар тушаалаар баталсан *“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”*;
- Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан *“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”*;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Үндсэн мэдээлэл

Төсвийн тухай хуульд *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”* гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг” гэж заасан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын шилжүүлгийг тооцох аргачлалыг баталсан Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоол хүчингүй болж, Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаартай “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай” тогтоолыг шинэчлэн баталсан байна.

Мөн орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан *“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”*-ыг баримтлан хэрэгжүүлж байсныг Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан *“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”*-аар зохицуулахаар өөрчилсөн байна.

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 88,555.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд аймаг, нийслэлийн ОНХС-д бүрэн хуваарилсан байна.

Хүснэгт 1. ОНХНС-ийн 2018 оны эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/Сая.төгрөг/			
№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Дотоодын НӨАТ-ын /5 хувь/	21,116.0	21,116.0
2	АМНАТ-ын /5 хувь/	9,950.7	9,950.7
3	Газрын тосны нөөц ашигласны төлбөр /30 хувь/	40,321.7	40,321.7
4	“Тогтвортой амьжиргаа-3” төсөл	17,166.7	17,166.7
	Нийт	88,555.0	88,555.0

/Эх сурвалж: Сангийн яам/



Хүснэгт 2. ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг

/сая төгрөг/

№	Аймаг, нийслэл	ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлгийн дүн	Үүнээс: Тогтвортой амьжиргаа-3 төслөөс	
			Дэмжлэг	Урамшуулал
1	Архангай	3,597.7	845.1	26.2
2	Баян-Өлгий	4,940.7	1,073.2	11.7
3	Баянхонгор	3,795.7	825.4	22.5
4	Булган	2,312.2	532.3	47.8
5	Говь-Алтай	3,399.3	726.8	32.0
6	Дорноговь	3,275.6	706.8	104.6
7	Дорнод	3,650.4	818.0	28.2
8	Дундговь	2,075.2	457.9	70.3
9	Завхан	3,471.2	771.0	20.2
10	Өвөрхангай	4,374.3	1,026.9	33.7
11	Өмнөговь	3,387.7	725.0	137.3
12	Сүхбаатар	2,666.1	574.7	49.1
13	Сэлэнгэ	3,838.7	894.6	31.1
14	Төв	3,211.9	757.0	37.2
15	Увс	4,227.7	927.0	17.5
16	Ховд	4,423.2	978.6	16.8
17	Хөвсгөл	5,455.4	1,244.0	45.1
18	Хэнтий	3,110.7	703.2	53.7
19	Дархан-Уул	2,933.2	710.2	8.9
20	Улаанбаатар	16,258.5	-	-
21	Орхон	3,504.9	824.9	49.1
22	Говь-Сүмбэр	644.6	140.5	60.8
	ДҮН	88,555.0	16,263.0	903.7

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг нэмэлт хөрөнгө хуваарилах замаар урамшуулах, төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар Олон Улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу дээрх төслөөс 328 сумдын ОНХС-д 16,263.0 сая төгрөгийн дэмжлэг, 163 сумдын ОНХС-д 903.7 сая төгрөгийн урамшуулал, нийт 17,166.7 сая төгрөгийг олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн гол зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах замаар иргэдийн тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах орчин бүрдүүлэхэд чиглэнэ. Энэ зорилгыг хангахын тулд Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд орон нутгийн өөрийн удирдлагын үйл ажиллагаа болон иргэд, олон нийтийн оролцоо чухал нөлөөтэй юм.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх иргэдийн мэдээлэл, оролцоог үнэлэх зорилгоор 21 аймаг болон нийслэлийн нийт 11,073 иргэнээс санал асуулга авч нэгтгэн дүгнэв.



БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ЭХ ҮҮСВЭР ТУС БҮРЭЭР БҮРДҮҮЛЭХ АЖИЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт дахин хуваарилалт хийх замаар орон нутагт төсвийн дэмжлэг, туслалцаа үзүүлдэг механизм бусад улс орнуудад байдаг. Ингэснээр орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, орон нутаг бие даан хөгжих бололцоог хангах, орон нутгийн хэрэгцээ шаардлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, түүнд шаардлагатай төсөв хөрөнгийг төсөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх үйл явцад иргэд оролцдог байна.

Түүнчлэн сайн засаглалыг бэхжүүлэх үндсэн шалгуур нь төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх явдал гэж олон улсад хүлээн зөвшөөрдөг¹. Үүний тулд төсвийн мэдээллийг ил тод болгох, төсвийн төвлөрлийг сааруулах нь чухал ач холбогдолтой бөгөөд манай улс 2011 оноос Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, уг хуулиар орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор ОНХС-г үүсгэн, улсын төсвөөс орон нутгийн төсөвт дахин хуваарилалт хийх замаар эх үүсвэрийг нь бүрдүүлэхээр хуульчилсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1² дэх хэсэг болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.1-д заасан эх үүсвэрийн хүрээнд нийт 88,555.0 сая төгрөгөөр төлөвлөж Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар баталсан байна.

Хүснэгт 3. ОНХНС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт

(сая төгрөг)

Эх үүсвэр		Төсвийн тухай хуулийн заалт	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийн аргачлал	Батлагдсан дүн
ОНХНС	Дотоодын НӨАТ-ын орлогын 5 хувь	59.1.1	2.1.1	21,116.0
	АМНАТ-ийн орлогын 5 хувь	59.1.2	2.1.2	40,321.7
	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	59.1.5	2.1.4	9,905.7
	“Тогтвортой амьжиргаа-3” төслийн дэмжлэг	59.1.3	2.1.3	16,263.0
	“Тогтвортой амьжиргаа-3” төслийн урамшуулал			903.7
Нийт				88,555.0

Эх сурвалж: Сангийн яам

¹ Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн. “Төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоог дээшлүүлэх хөшүүрэг, арга зам” судалгаа- УБ. 2014 он.

² 59.1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

59.1.1. импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 %

59.1.2.ашигт малтмалын тухай хуулийн 473 дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5%

59.1.3. орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

59.1.5. газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.



ОНХНС-ийн эх үүсвэрийг 2018 оны төсөвт тусгаж төлөвлөхдөө импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын болон АМНАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогоос Төсвийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож, төлөвлөсөн бол *“Тогтвортой амьжиргаа-3”* төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг нэмэлт хөрөнгө хуваарилан урамшуулах замаар 163 сумын ОНХС-д 903.7 сая төгрөгийн урамшуулал, 328 сумын ОНХС-д 16,263.0 сая төгрөгийн дэмжлэг олгохоор төлөвлөж бүрдүүлжээ.

ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2³, 59.3⁴ дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”*-ын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, аймгийн төвөөс нийслэл хот хүртэлх хот хоорондын замын урт, орон нутгийн татварын идэвх санаачилга зэрэг шалгуур үзүүлэлтийг тус тус үндэслэн тооцоолсон байна.

Сангийн сайдын 2017 оны *“Төсвийн хуваарь батлах тухай”* 388 дугаар тушаалын 6-р хавсралтаар *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2018 онд аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарь”*-ийг баталж, 2018 оны *“Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай”* 65 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2018 онд аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарь”*-ийг өөрчлөн баталсан байна.

Хүснэгт 4. ОНХНС-аас 2018 онд ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн
төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

Улирал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	16,040.1	12,255.9	(3,784.2)
II	32,950.1	36,734.3	3,784.2
III	16,750.0	16,750.0	-
IV	22,814.8	22,814.8	-
Нийт	88,555.0	88,555.0	-

³ 59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна;

59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6, 60.7-д заасан хувь хэмжээгээр хуваарилах. /Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/, /Энэ хэсгийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

59.2.4.энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй;

⁴ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс;

59.3.2.хүн амын тоо;

59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.



Хүснэгтээс үзэхэд аймаг, нийслэлийн ОНХС-д 2018 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хоцорч 2 дугаар улиралд төвлөрсөнтэй холбоотойгоор 1 дүгээр улиралд олгогдох байсан 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилт 2 дугаар улиралд олгогдсон байна.

1.2. Зарим аймгууд ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө зөвхөн ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгээр төлөвлөж бусад эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

Аймаг, нийслэл нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2⁵ болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2-т заасны дагуу 2018 оны ОНХС-ийн эх үүсвэрийг 5 төрлийн орлогоос бүрдүүлэхээр заасны дагуу Баянхонгор, Хэнтий аймгууд бүрэн төлөвлөж, бүрдүүлсэн байна.

Харин Баян-Өлгий, Дархан-Уул, Нийслэл нь зөвхөн ОНХНС-ийн орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1⁶ болон дээрх аргачлалын 2.2.3, 2.2.4 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дор дурдсан аймгууд ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлэх талаар хангалтгүй ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Засгийн газрын 2012 оны 244 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1-д заасантай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Архангай, Говь-Алтай аймгууд орон нутгийн орлогоос бүрдүүлэх эх үүсвэрүүдээс нэг эх үүсвэрийг төлөвлөж, бүрдүүлсэн;
- Говь-Сүмбэр, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд орон нутгийн орлогоос журамд заасан нэр төрлөөс 2 эх үүсвэрээр төлөвлөж, бүрдүүлсэн;
- Булган, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс аймгууд эх үүсвэрийн төлөвлөлт хийгдээгүй боловч бүрдүүлэлт, гүйцэтгэл гаргасан;
- Дорноговь аймаг 1 эх үүсвэр төлөвлөж, 2 эх үүсвэрээс бүрдүүлэлт хийсэн, Дорнод аймаг 1 эх үүсвэр төлөвлөж, 3 эх үүсвэрээс бүрдүүлэлт хийсэн, Дундговь аймаг 2 эх үүсвэр төлөвлөж, 3 эх үүсвэрээс бүрдүүлэлт хийсэн, Орхон аймаг 1 эх үүсвэр төлөвлөсөн боловч эх үүсвэрийн бүрдүүлэлт байхгүй.

/Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/

Аймаг, нийслэлийн ОНХС-д 2018 онд нийт 123,286.3 сая төгрөгийн эх үүсвэр төвлөсөн бөгөөд 14 хувь буюу 17,360.3 сая төгрөг нь өмнөх оны үлдэгдэл, 71.8 хувь буюу 88,555.0 сая төгрөг нь ОНХНС болон улсын төсвийн шилжүүлэг, 7.8 хувь буюу 9,736.2 сая төгрөг нь татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр, 3.7 хувь буюу 4,621.2 сая төгрөг нь дотоод, гадаадын хандив тусламж, 2.7 хувь буюу 3,013.9 сая төгрөг нь зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэрээс бүрдсэн байна.

Хүснэгт 5. Орон нутгийн хөгжлийн санд 2018 онд төвлөрсөн эх үүсвэр

(сая төгрөг)

Эх үүсвэр	Дүн	Хувийн жин
Өмнөх оны үлдэгдэл	17,360.3	14 хувь
ОНХНС болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг	88,555.0	71.8 хувь
Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	9,736.2	7.8 хувь

⁵ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

⁶ төсвийн зарчмыг мөрдлөг болгох;



Хандив, тусламж	4621.2	3.7 хувь
Зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэр	3,013.9	2.7 хувь
НИЙТ	123,286.3	100 хувь

Эх сурвалж: Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын тайлангаас.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 онд төвлөрсөн эх үүсвэрийг 2017 оны эх үүсвэртэй харьцуулахад ОНХНС болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг өссөн байхад бусад эх үүсвэрийн төлөвлөлт буурсан байна. График 1-д харуулбал:



Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нар ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийг хуульд заасан аргачлалын дагуу эх үүсвэр тус бүрээр төлөвлөөгүйгээс сум, дүүргүүдэд төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр дутагдах нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

1.3. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг зарим аймгууд батлагдсан аргачлал, хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүрэгт олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8.2, 8.3-т заасны дагуу хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг аргачлал⁷-д заасан хувиар тооцож олгохоос зарим аймгуудад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Баян-Өлгий аймаг АОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Алтай сумд 0.5 сая, Баяннуур сумд 9.7 сая, Ногоон сумд 4.2 сая буюу нийт 14.4 сая төгрөгийг дутуу;
- Говь-Алтай аймаг ОНХС-ийн орлогын шилжүүлгийг төлөвлөж хуваарилсан баримтгүй, мөн 9 сумд 103.0 сая төгрөгийг дутуу;
- Ховд аймаг Жаргалант сумд 7.0 сая, Үенч сумд 7,8 сая буюу нийт 14.8 сая төгрөгийг илүү;

⁷ Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;

8.3. “Аймаг, нийслэл нь энэ аргачлалын 8.2-т заасны дагуу хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг дараах байдлаар тооцно:

8.3.1. хүн амын тооноос хамаарах -40%

8.3.2. алслалтаас хамаарах -30%

8.3.3. нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах -30%;



- Хөвсгөл аймаг АОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу шилжүүлээгүй;
- Хэнтий аймаг Батноров сумд 5.0 сая, Батширээт сумд 5.0 сая, Биндэр сумд 6.0 сая, Галшар сумд 5.0 сая, Өмнөдэлгэр сумд 2.0 сая буюу нийт 23.0 сая төгрөгийг дутуу, Бэрх тосгонд 5.0 сая, Баянмөнх сумд 5.0 сая, Дэлгэрхаан сумд 5.0 сая, Мөрөн сумд 6.0 сая, Хурх тосгонд 2.0 сая төгрөг буюу 23.0 сая төгрөгийг илүү шилжүүлсэн.

Аймгууд АОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлал, хуваарийн дагуу олгоогүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2⁸, 41.2.3⁹, 41.2.4¹⁰, 41.2.5¹¹ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг сумдад шилжүүлэхдээ Төсвийн тухай хууль болон дээрх аргачлалыг мөрдөж, батлагдсан дүн, хуваарийн дагуу шилжүүлэх шаардлагатай байна.

⁸ “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”;

⁹ “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”;

¹⁰ “төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах”;

¹¹ “энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх”;



БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ЧИГ ҮҮРГЭЭС БУСАД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2.1. Зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримталж ажиллаагүй байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нь 2018 онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5¹², 6.5.6¹³, 63¹⁴ дугаар зүйлийн 63.1¹⁵, 63.2¹⁶, 63.3¹⁷, 63.4¹⁸ дэх хэсэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тус тус мөрдөх зохицуулалттай байна.

А) Баг, хорооны иргэдийн Нийтийн хурлаар санал аваагүй, сум, дүүргийн ЗДТГ нь эрэмбэлээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан байна.

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлд тухайн шатны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан жагсаалт бэлтгэн олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

Мөн “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5, 6 дугаар бүлэгт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд хийгдэх ажлуудыг дараах байдлаар тусгасан байна.

№	Баг, хорооны Засаг дарга	Баг, хорооны ИНХ-ын дарга
1	ИНХ-ын зарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө тухайн баг, хорооны айл өрх бүрт хүргэж, зар хүлээн авсан тухай гарын үсгийг өрх бүрээс авч баталгаажуулна.	Ирэх онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг жил бүрийн 5 сард багтаан зохион байгуулна.
2	ИНХ-д өмнөх жилд ОНХС-аас хэрэгжүүлсэн Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар тайлагнана. Түүнчлэн хөндлөнгийн хянагч, үнэлэгч нарын тайланг мөн сонсоно.	Хурлын ирцийг бүртгэн оролцоогчдоор гарын үсэг зуруулж, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж тэмдгээр баталгаажуулна.
3	ИНХ-д иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, харьяа сум, дүүргийн ЗД-аас ирүүлсэн хөгжлийн бодлоготой	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нэг бүрийн авсан саналыг Нийтийн

¹² 6.5.5. Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

¹³ 6.5.6. Төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаа дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх;

¹⁴ 63 дугаар зүйл. Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах;

¹⁵ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

¹⁶ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

¹⁷ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

¹⁸ Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална



	уялдуулсан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцүүлнэ.	хурлаар баталж, тогтоолоор баталгаажуулна.
4	ОНХС-аас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалтыг нэг бүрчлэн хэлэлцүүлж, санал тус бүрд нь гар өргөх, эсвэл хуудсаар санал авна.	“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 2 дугаар хавсралтад заасан “Баг хорооны иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл”-ийн дагуу бэлтгэнэ.
	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга	Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ
5	ОНХС-ийн хөрөнгөөр дараа жил хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг АН-ийн хөгжлийн бодлого, чиглэл, ЗД-ын мөрийн хөтөлбөрт туссан үйл ажиллагаа, урьд онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг харгалзан боловсруулна.	ОНХС-ийн хөрөнгөөр дараа жил хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг төрөл тус бүрээр хэлэлцэж, төсвийн төсөлд тусган баталгаажуулан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын маягт-3-ын дагуу бэлтгэнэ.
6	Дээрх жагсаалтад сум дүүргийн иргэдийн саналыг авсан АН-ийн чиг үүрэгт хамаарах саналын жагсаалтын мөн оруулна. Иргэд, олон нийтийн саналыг цахим хуудас, санал асуулгын хуудас ашиглах, ярилцлага зохион байгуулах болон дэвшилтэт технологийн бусад хэлбэр ашиглах замаар явуулна.	
7	АН-ийн ЗД Иргэний танхимаар хэлэлцүүлсэн Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн арга зүйн зөвлөмж гаргах үүрэг бүхий 7-оос доошгүй хүнтэй Ажлын хэсгийг ЗДТГ, ХБХ, СТСХ-ийн холбогдох ажилтнууд болон Иргэний нийгмийн төлөөлөл оролцуулан ХБХ-ийн даргаар ахлуулан байгуулна.	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тухайн онд төлөвлөж ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг дараа жилийн төсөвт тусгаж батална.
8	АН-ийн ЗД нь иргэд, олон нийтээс хамгийн их санал, Ажлын хэсгийн санал дүгнэлтээр баталгаажсан Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн иргэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл иргэний танхимаар дамжуулан 11 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулна.	

Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн талаар баримт материал бүрдүүлсэн боловч иргэдийн оролцоо, идэвх муу байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Судалгаанд нийт 11,073 иргэн хамрагдсан бөгөөд дүгнэж үзэхэд “Та ОНХС-ийн талаар хэр мэдээлэлтэй вэ?” гэсэн асуултад 5,445 иргэн буюу 49.2 хувь нь “хангалттай”, 50.8 хувь нь “хангалтгүй” мэдээлэлтэй гэж, “Та орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомжийг судалж үзсэн үү?” гэсэн асуултад 4,232 иргэн буюу 38.2 хувь нь “Тийм”, 61.8 хувь нь “Үгүй” гэж хариулсан нь гэж хариулсан байна.

“Таны баг, хорооны Засаг дарга 2018 онд ОНХС-ийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?” гэсэн асуултад 5,716 иргэн буюу 51.6 хувь нь “Тийм” 2,476 иргэн буюу 22.4 хувь нь “Үгүй”, 26.0 хувь нь “Сайн мэдэхгүй байна” гэж хариулсан.

Мөн “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?” гэсэн асуултад 4,683 иргэн буюу 42.3 хувь нь “Хангалттай”, 3,351 иргэн буюу 30.3 хувь нь “Хангалтгүй”, 27.4 хувь нь “Мэдэхгүй байна” гэж хариулсан байна.



Санал асуулгын дүнг нэгтгэн дүгнэвэл төсвийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлж, иргэдийн оролцоо хяналтыг бий болгох ОНХС-ийн зорилт бүрэн хангагдаагүй гэж үзэж болохоор байна.

Монгол Улсын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд нийт 122,284.4 сая төгрөгийн өртөгтэй 4,500 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан бөгөөд орон нутгийн хөгжлийн бодлого, ЗД-ын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтуудтай уялдуулан төлөвлөх, иргэдээс батлагдсан маягтаар нээлттэй санал, асуулгыг жил бүр зохион байгуулж саналыг эрэмбэлэх ажил тодорхой хэмжээгээр хэвшиж байгаа боловч холбогдох журам, зааврыг баримтлаагүй зөрчлүүд гарсаар байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзэх/ Тухайлбал:

Архангай аймгийн Тариат, Эрдэнэбулган, Булган, Цахир сумдад иргэдээс санал аваагүй 95.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг;

Баян-Өлгий аймгийн Баяннуур, Бугат, Булган, Буянт, Ногооннуур, Сагсай, Улаанхус, Цэнгэл, Өлгий сумдад иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй 692,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 төсөл, арга хэмжээг;

Булган аймгийн Орхон, Дашинчилэн, Бүрэгхангай сумдад иргэдээс санал аваагүй нийт 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээг;

Говь-Алтай аймгийн Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Шарга, Эрдэнэ сумдад иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй нийт 356.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл, арга хэмжээг;

Дорноговь аймгийн Сайншанд, Дэлгэрэх, Замын-Үүд сумдад иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй нийт 62.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг;

Дорнод аймгийн Хөлөнбуйр, Матад, Чулуунхороот, Чойбалсан, Баян-Уул, Баяндун, Хэрлэн сумдад санал асуулгад оролцсон иргэдийн ирцийн бүртгэл байхгүй, санал асуулгын хуудсыг иргэдийн өмнөөс нэг хүнээр олон удаа бөглүүлсэн, саналын хуудсанд гарын үсэг зуруулаагүй, мөн Матад, Дашбалбар, Булган сумдад иргэд, олон нийтийн саналыг аваагүй, эрэмбэлэгдсэн жагсаалтад тусгагдаагүй нийт 6,2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг;

Завхан аймагт иргэдийн саналыг авч, зохих журмын дагуу эрэмбэлээгүй 27 төсөл, арга хэмжээг;

Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдад ажлыг эрэмбэлэхдээ их санал авснаас бага санал авсан ажлаа эрэмбэлээгүй;

Сүхбаатар аймгийн Асгат, Баяндэлгэр сумдад иргэдээс санал аваагүй нийт төсөвт өртөгтэй 16.7 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг;

Сэлэнгэ аймгийн Ерөө, Зүүнбүрэн, Орхонтуул, Сант, Хушаат, Орхон, Түшиг, Сүхбаатар сумдад багийн ИНХ нь хууль журамд заасан хугацаанд хуралдаагүй, ирц бүрдээгүй байхад хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцож, иргэдийн саналыг авч эрэмбэлсэн, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтлөөгүй, хурлын ирцийг оролцогчдын гарын үсгээр баталгаажуулаагүй, мөн Түшиг сумд иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 33.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг;

Хөвсгөл аймгийн зарим сумдад журамд заасан хугацаанд багтаан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг баг, хорооны ИНХ-аар хэлэлцэх, санал хураах хурлыг 5 дугаар сард багтаан зохион байгуулаагүй;

Хэнтий аймгийн Дархан, Цэнхэрмандал, Баянмөнх сумдад иргэдээс санал аваагүй нийт 138.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 хөтөлбөр төсөл, арга хэмжээг тус тус төлөвлөж, баталсан;

Нийслэлийн БНД нь 3, 5 дугаар хорооноос хурлын тэмдэглэлгүй ирүүлсэн төсөл, арга хэмжээг үндэслэл болгон төлөвлөж, баталсан.

Аудитаар илэрсэн зөрчил болон иргэдээс авсан санал асуулгаас үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх иргэдийн ойлголт дутмаг, идэвх оролцоо хангалтгүй, ОНХС-тай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны зүгээс тус сангийн мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, танилцуулах, ил тод байдлыг хангах талаар арга хэмжээ зохион байгуулаагүй байна.



Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлан олон нийтийн оролцоог бүрэн хангаж, иргэдийн саналыг үнэн бодитой тусгах, ОНХС-ийн мэдээллийг иргэдэд хүргэх, тайлагнах, танилцуулах талаар арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Аудитаар иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг эрэмбэлэгдсэн жагсаалтад оруулж, батлуулсан нийт 80 төсөл, арга хэмжээний 3,669.4 сая төгрөгийн зөрчилд 3,223.0 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 446.4 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн. /Хавсралт 4/

Б) Зарим аймаг, сум ОНХС-ийн хөрөнгөөр техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Зарим аймаг, сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журам, зааврын дагуу ТЭЗҮ, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан нь “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3, Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан шаардлагыг хангаж ажиллаагүй байна. Тухайлбал:

Булган аймгийн Бугат, Дашинчилэн, Могод сумдад гэрэлтүүлгийн урсгал зардалд нийт 4.5 сая төгрөг, Сэлэнгэ суманд техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв батлагдаагүй нийт 20.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээг;

Говь-Алтай аймагт техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгаагүй нийт 1,214.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 97 арга хэмжээг;

Завхан аймагт хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдаагүй-8, аймаг, сумдын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд-38, ТЭЗҮ, зураг төсөв батлагдаагүй арга хэмжээг төлөвлөсөн-14, бусад эх үүсвэртэй давхардуулсан-10 төсөл, арга хэмжээг;

Нийслэлд нийт зөрчлийн 84.9-86.3% нь урьдчилсан тооцоолол, батлагдсан зураг, төсөвгүй, 14.1-15.4% хувь нь зохих зөвшөөрөл, дүгнэлт, техникийн нөхцөлийг аваагүй төсөл, арга хэмжээг;

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлахдаа санхүүжих эх үүсвэрийг бодитой тооцоогүй 18 төсөл арга хэмжээнд 1,583.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь батлагдсан санхүүжилтээс 51.2 сая төгрөгөөр илүү;

Сүхбаатар аймгийн Уулбаян, Эрдэнэцагаан, Халзан, Сүхбаатар сумдад урьдчилсан тооцоолол, батлагдсан зураг, төсөвгүй 149.5 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг баталснаас, гүйцэтгэлээр 225.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 76.4 сая төгрөгийг илүү санхүүжүүлсэн;

Сэлэнгэ аймгийн Ерөө, Орхонтуул, Сүхбаатар, Хушаат, Цагааннуур сумдад зураг, төсөв, тооцоо судалгаагүйгээр нийт 289.1 сая төгрөгийн өртөг бүхий 16 төсөл, арга хэмжээг;

Төв аймгийн Баянхангай сумын мал эмнэлэг үржлийн тасгийн автомашины засварын ажил, Баяндэлгэр, Заамар сумд золбин нохой муур устгалын ажлыг ОНХС-ийн төлөвлөгөөнд тусган сумын ИТХ-аар баталсан, Цээл сумын ахуй үйлчилгээний барилга барихад 62.2 сая төгрөг батлагдаж, санхүүжилт батлагдсаны дараа зураг, төсвийг хийлгэхэд 165.5 сая төгрөгийн өртөгтэй ажлын зураг, төсөв хийгдсэн;

Хэнтий аймагт зураг төсөл, ажлын даалгавар болон төсвийн төсөл нь бэлэн болоогүй 141.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 35 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тус тус төлөвлөж батлуулсан.

Дээрх аймаг, сум ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн жагсаалтыг гаргаж, тухайн жилийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан боловч урьдчилсан тооцоолол, ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөв батлагдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан нь



Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹⁹, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7²⁰ дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Мөн сумдын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг, төсвийг урьдчилж хийхгүй байгаа нь дараах хүндрэлтэй холбоотой байна. Үүнд:

- “ОНХС-ийн шилжүүлгийн орлогоос сумдад хуваарилах тоо хэмжээ нь урьдчилан мэдэгддэггүй учир хуваарилсны дараа тоо хэмжээнд нь тохируулж төсөл, арга хэмжээг сонгодог;
- Зураг, төсөв зохиогч нь ажлын хөлсийг урьдчилж авах шаардлага тавьдаг тул урьдчилж хийлгэх хөрөнгө санхүү байдаггүй;
- Зураг, төсвийг урьдчилж хийлгээд тухайн төсөл, арга хэмжээ ИТХ-аар батлагдахгүй тохиолдолд үргүй зардал гарах, эх үүсвэр нь шийдэгдэхгүй өр төлбөр үүсэх зэрэг эрсдэл үүсдэг байна.

Хэдийгээр сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг, төсвийг тухайн шатны ИТХ-аар батлахын өмнө болон батлагдсаны дараа төсөвт өртөгт нь багтаан хийж байгаа ч үнэн зөв эсэхийг магадлах ажил огт хийгдэхгүй байна.

Аудитаар ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөв батлагдаагүй нийт 142 төсөл, арга хэмжээний 4,683.8 сая төгрөгийн зөрчилд 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 4,517.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 165.9 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн. /Хавсралт 4/

2.2. ОНХС-ийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ шаардлагыг хангах зардалд зарцуулж байна.

А) Зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд өмнөх оноос шилжүүлсэн 306, шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4,160 буюу нийт 4,466 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулсан бөгөөд 5.4 хувь буюу 241 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 80.1 хувь буюу 3,579 ажлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 14.5 хувь буюу 646 ажлыг шууд худалдан авсан байна. /Хавсралт-2/

Хүснэгт 6. ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тоон мэдээлэл

(тоогоор)

Өмнөх оноос шилжсэн	Тайлант оны ажил	Нийт ажил	Худалдан авах ажиллагааны журам				Шууд худалдан авалт
			НТШ-ын журам	Тендер шалгаруулалтын онцгой журам			
				ХТШ	Харьцуулалтын арга	ШГБ	
306	4,160	4,466	241	10	1007	2,562	646

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн ТАГ-ын аудитын тайлан.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон зарим үнэлгээний хороо, ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион

¹⁹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

²⁰ Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хууль, заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн бусад зөвшөөрөлтэй байх.



байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1²¹, 7.2²², 8 дугаар зүйлийн 8.5²³, 14 дүгээр зүйлийн 14.1.5²⁴, 26 дугаар зүйлийн 26.4²⁵, 29 дүгээр зүйлийн 29.1²⁶, 29.2²⁷ 30 дугаар зүйлийн 30.1.3²⁸, 33 дугаар зүйлийн 33.2.1²⁹, 33.3³⁰, 47 дугаар зүйлийн 47.4³¹, 47.6³², 47.8³³, 49 дүгээр зүйлийн 49.1³⁴, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4³⁵, 58 дугаар зүйлийн 58.3.3-58.3.7, 58.4.3-58.4.8 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 39 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын 2.2, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.3-т заасныг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- **Баянхонгор** аймгийн Бөмбөгөр суманд 25.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий өвс, хадлан бэлтгэх ажлыг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн, Баянхонгор суманд Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 22 дугаар зүйлийг зөрчин “Сити-00” барих ажлыг 79.6 сая төгрөгийн өртөг бүхий гэрээг “Жаргантайн хөх тариа” ХХК-тай байгуулан 54.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон, мөн Баянхонгор сумын нийтийн эзэмшлийн талбайд хогийн сав нийлүүлэх ажлыг “Сайн үйлс баян” хоршоотой 8.5 сая төгрөгийн гэрээ байгуулан 8.0 сая төгрөгийг олгосон боловч гүйцэтгэгч нар гэрээний үүргээ биелүүлээгүй гэрээт хугацаандаа ажлыг хүлээлгэн өгөөгүй;
- **Булган** аймагт “Эрдмийн өргөө цогцолбор” сургуулийн ариун цэврийн байгууламжийн 40.0 сая төгрөгийн өртөгтэй засварын ажилд тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан;
- **Дорноговь** аймгийн Иххэт сум 19.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Баян багт иргэний танхим шинээр барих” ажил, 22.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сумын төвийн ундны усны нөөцийг шинээр тогтоолгох” ажлын гүйцэтгэгчдийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй, Өргөн сум 19.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж худалдан авах” ажлын үнийн санал ирүүлэх мэдэгдлийг 2 этгээдэд хүргүүлсэн, Иххэт сум 19.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Баян багт иргэний танхим шинээр барих”, Мандах сум 13.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн

²¹ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:...

²² Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

²³ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно;

²⁴ тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

²⁵ Энэ хуулийн 26.2-т заасан этгээд, захиалагч байгууллагын төлөөлөгч энэ зүйлийн 26.3-т заасан тэмдэглэлд гарын үсэг зурна;

²⁶ Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ;

²⁷ гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах;

²⁸ шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн

²⁹ техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх;

³⁰ Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно;

³¹ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна;

³² Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна;

³³ Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна;

³⁴ Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална;

³⁵ “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”.



- бялдаржуулах танхимын засвар”, Хөвсгөл сум 13.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Соёлын төвийн тайз засвар”-ын ажлыг олон нийтийн оролцоотой гүйцэтгэсэн;
- **Дорнод** аймгийн Баяндун сум “Хайрхан багийн төвийг хашаажуулах” ажлын гэрээний хугацаа дуусаж, гүйцэтгэгч ажлыг гүйцэтгээгүй байхад урьдчилгаа байдлаар олгосон гэрээний үнийн дүнгийн 50 хувь болох 3.5 сая төгрөгийн санхүүжилтийг буцаан төлүүлээгүй зардлаар бүртгэсэн, Баян-Уул сум 15.0 сая төгрөгийн төсөвтэй “Залуус талбайн тохижилт”-ын ажлын даалгаврыг боловсруулахдаа үнийн судалгаа хийгээгүйгээс зах зээлийн үнээс өндөр үнэтэй бараа нийлүүлэгдсэн, Чулуунхороот сум “Бойны цэгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тэлэх, засварлах” ажлын 4.4 сая төгрөгийн ажил гэрээнд заасан хугацаанд бүрэн хийгдээгүй байхад санхүүжилтийг олгосон, Матад сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Мал нядалгааны цехийн тоног төхөөрөмж нийлүүлэх, хашаа бариулах” ажлын гэрээний хугацаа дуусаж, гүйцэтгэгч “Батцагаан өргөө” ХХК нь ажлыг гүйцэтгээгүй байхад урьдчилгаа байдлаар олгосон гэрээний үнийн дүнгийн 70 хувь болох 56.0 сая төгрөгийн санхүүжилтийг буцаан төлүүлээгүй зардлаар бүртгэсэн, Хэрлэн сумын 8 дугаар багт хийгдсэн 14.6 сая төгрөгийн “Тоглоомын талбай байгуулах” хөрөнгө оруулалтын ажил нь чанаргүй хийгдсэн, зарим тоглоомын эд анги байхгүй;
 - **Нийслэлд** нийт 110.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Гэр хорооллын гудамжнуудад шороо асгах, түрэх, тэгшлэх /СХД, 6, 7, 24 дүгээр хороо/” төсөл арга хэмжээг зохион байгуулсан үнэлгээний хороо нь тендерийн бичиг баримтыг захиалагчаар батлуулаагүй нь Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3.2 заалт, 314.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах болон шалгараагүй тухай мэдэгдлийг тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлээгүй, үүнээс шалтгаалан тендерт шалгараагүй оролцогчийн гомдол гаргах эрх хязгаарлагдсан, 854.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээг зохион байгуулсан үнэлгээний хороо нь тендерийн бичиг баримтыг ТБОНӨХБӨҮХАТ хуулийн дагуу боловсруулаагүй, 1.266.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 төсөл, арга хэмжээг зохион байгуулсан үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3.5.4 дэх заалтыг тус тус зөрчсөн;
 - **Орхон** аймгийн Жаргалант сум 210.9 сая төгрөгийн 4 ажил нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй;
 - **Сүхбаатар** аймгийн Асгат сум нарийн ногоо тариалах зорилгоор хүлэмж худалдан авахад 1.2 сая төгрөг шилжүүлсэн боловч гүйцэтгэгч хөрөнгийг нийлүүлээгүй, Түмэнцогт сум төв дагуух газрыг тэгшлүүлэхээр “Гашууны гол” ХХК-тай гэрээ байгуулсан боловч 5.0 сая төгрөгийн ажлыг хийгээгүй, Онгон сум Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг гүйцэтгүүлж санхүүжилтийг олгохдоо 1.1 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг илүү шилжүүлсэн;
 - **Сэлэнгэ** аймаг 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, 115.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн ГХБХБГ, ЭМГ-ын дарга болон сумдын Засаг дарга нарт шилжүүлсэн;
 - **Төв** аймаг зарим ажлын гүйцэтгэгчээс суутган тооцох захиалагчийн зардал болох захиалагч, зохиогчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, зураг, төсвийн үнэ зэрэг зардлуудыг суутган тооцолгүй, гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгосон. Мөн гэрээт ажлын гүйцэтгэл дутуу, гэрээний хугацаа эхтэрсэн, комиссын актаар хүлээж аваагүй ажлын санхүүжилтийг бүрэн олгосон;
 - **Хөвсгөл** аймгийн ЗДТГ-ын дарга нь Сангийн сайдын 2014 оны 5/6765 дугаартай албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр 2018 оны 05 сард А/68 дугаар тушаалаар ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.3-г баримтлан аймгийн ОНӨГ-т захиалагчийн эрх, үүргийг шилжүүлсэн боловч аймгийн ЗД-ын захирамжаар үнэлгээний хороог байгуулсан. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалттай нийцэхгүй байна;
 - **Хэнтий** аймагт 10.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээний 14 ажлыг олон нийтэд нээлттэй зарлаагүй, мөн 10.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй нийт 55 бараа, ажил, үйлчилгээний 11-ийг шууд худалдан авч хууль, журмыг сонгоход баримтлах босго үнийг зөрчжээ.

Дээрх худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлүүд нь дараах нийтлэг шалтгаантай байна. Үүнд:



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу захиалагчаас тендер шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн А-3 сертификаттай хүнийг оруулж, 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх зүйн зохицуулалттай байтал орон нутагт А-3 сертификаттай оролцогч цөөхөн, үүнээс шалтгаалж хэд хэдэн үнэлгээний хороонд давхар ажиллуулдаг, ашиг сонирхлын зөрчил үүсдэг зэргээс хууль, журам, зааврыг зөрчиж зохион байгуулдаг;
- "Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллаагүй;
- Зарим сумд худалдан авах ажиллагаанд өрсөлдөөнийг дэмжиж нэг төрлийн болон ижил төстэй ажлыг нэгтгэж багцлах замаар тендер шалгаруулалтын журмыг сонгож, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж ажиллаагүй;
- Мөн сумдын ОНХС-ийн хөрөнгө жилээс жилд багасаж, түүнтэй холбоотой хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний төсөвт өртөг нь босго үнэд хүрэхгүй жижиг тохижилт, засварын ажил нэлээдгүй хийгдэж байгаатай холбоотойгоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ихэнх хувийг шууд гэрээ байгуулан иргэдийн бүлгээр гүйцэтгүүлдэг;
- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тендер зарласан боловч тендер ирүүлээгүй тохиолдолд төсвийг хувааж шууд гэрээ байгуулдаг;
- Санхүүжилт дутуу олгосон шалтгаан нь санхүүжилт авахад бүрдүүлэх баримт материалын дутуугаас болон жилийн эцэст шилжүүлсэн зарим санхүүжилт нэр дансны зөрүүгээс болж буцдаг;
- Мөн урьдчилгаа санхүүжилт авч, ажлаа эхэлсэн боловч цаг агаар хүйтэрсэнтэй холбоотой ажлыг хойшлуулсан нь дутуу хэрэгжсэн зэрэг тус тус шалтгаанууд нөлөөлсөн байна.

Иймд алдаа зөрчлийг арилгаж, сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг зөрчсөн 2,745.3 сая төгрөгийн зөрчил гаргасныг илрүүлж, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 2,249.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 22 албан шаардлага, 495,7 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн. /Хавсралт 4/

Б) ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11³⁶, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7³⁷-д аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон байна.

Зарим аймаг, сумдын Засаг дарга нь Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг

³⁶ Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй;

³⁷ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүд;



үүргүүдийг ялгахгүйгээр тус сангаас санхүүжүүлж, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил давтагдсаар байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн, урсгал зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1³⁸, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.3³⁹, 4.4⁴⁰, 4.5⁴¹, 4.6⁴² дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- **Архангай** аймагт нийт 311.8 сая төгрөгийн зөрчил илэрсний 4.0 хувь буюу 12.6 сая төгрөг нь зориулалт бусаар зарцуулсан;
- **Баян-Өлгий** аймгийн Ногооннуур сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 3.0 сая төгрөгийг нэгдсэн жагсаалтад оруулж ИТХ-аар батлуулан зориулалт бусаар зарцуулсан, Сагсай сум ОНХС-ийн хөрөнгөнөөс 24.0 сая төгрөгийг малжуулах төсөл хэрэгжүүлж зориулалт бусаар зарцуулсан;
- **Баянхонгор** аймгийн Галуут, Баянбулаг сумд төрийн захиргааны төсөвт байгууллагын урсгал зардал болон хувийн хэвшлийн хөрөнгийн зардалд 24.8 сая төгрөгийг баталж 20.8 сая төгрөгийг зарцуулсан, мөн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 150.7 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээний зураг төсөв, инженер геологийн судалгааны ажлын санхүүжилт олгосноос 14.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- **Булган** аймгийн Бугат сум гэрэлтүүлгийн урсгал зардалд 1.2, Бүрэгхангай сумын ахмадын чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж 4.0, Дашинчилэн сум гэрэлтүүлгийн урсгал зардалд 1.4, Могод сум гэрэлтүүлгийн урсгал зардалд 1.9, Орхон сум эрэн гэр, асар майхан 14.0, Аймгийн ОНХС-аас цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд дуудлагын фургон автомашин 38.0, Аймгийн ОНХС-аас Баяннуур сумын эрүүл мэндийн төвийн автомашин 35.0 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна;
- **Говь-Алтай** аймгийн Алтай сумд “Жи мобайл”-ын сүлжээний ажлын үлдэгдэл санхүүжилт 12.0 сая, Жаргалан сумд цаг уурын харуулын барилгад 5.0 сая, Хөхморьт сумд хяналтын шатахууны зардалд 1.3 сая төгрөг, Цогт сумд багш сурагчдад тэмцээн уралдаан шагналд 5.6 сая, Чандмань сумд иргэдэд комбайн авахад дэмжлэг 5.0 сая, цаг уурын харуулын барилгын байр 6.0 сая, Аймгийн ОНХС-аас “Хоггүй цэвэр Алтай” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын хог зайлуулах, Хогийн бункер бэлтгэхэд 50.0 сая, Алтай хотын гэр хорооллын өрхийг 2 тарифт цахилгааны тоолуураар хангах ажилд 89.0 сая, “Үндэсний болон аймгийн хөтөлбөр хэрэгжүүлэх, бусад төсөл, арга хэмжээ”-ний зарцуулалтаас 294.6 сая төгрөгийг тус тус зориулалтын бусаар зарцуулсан;
- **Дархан-Уул** аймагт Аймгийн төв төсөл хөтөлбөр, арга хэмжээнд 194.7 сая, 176.7 сая төгрөгийн өртөг бүхий Дархан сумын 4 дүгээр баг, Дархан өртөөний нийтийн үйлчилгээний зориулалтын газарт “Худалдааны павильон барих, гадна инженерийн шугам сүлжээний холболт”-ын барилгын ажлын зураг төсөлд магадлал хийлгээгүй, “Шилмүүс” 2.5 сая төгрөгийн төсөл хэрэгжээгүй, “Баясгалант амьдрал, ахмадын тохилог хороолол” 2.0 сая, “Цэвэр орчин” орцны засварын 1.0 сая, 16 дугаар багийн “Ахмадын байр” 1.2 сая, “Эрүүл амьдрал” Хатан ухаант бүсгүйчүүд 1.0 сая, “Сэтгүүл зүйн хөгжлийн төв” 2.0 сая, “Залуусын дуу хоолой” 3.0 сая, Залуусын бүтээлийг дэмжих 4.5 сая, “10000 мэтгэлцэгч” 5.0 сая, 6 багийн гэр хорооллын зам засварт 1.5 сая, 3 дугаар багийн шороон зам захад 2.0 сая, 10 дугаар багийн ахмадын байрны засварт 3.0 сая, гудамжны гэрэлтүүлэгт 3.0 сая, нийт 29.2 сая төгрөгийн төслийн хөрөнгийн зорилго тодорхойгүй, “Ветмон” ХХК-ийн “Нохой засах” 2.4 сая төгрөгийн төслийн зарцуулсан анхан шатны баримт хангалтгүй, төсөл хэрэгжсэн нь тодорхойгүй, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон унадаг дугуйн замын гарц” 5.0 сая төгрөгийн төслийг аймгийн ЗДТГ-ын захирагчийн алба хангалтгүй гүйцэтгэсэн, Төрийн бус байгууллагуудад /зөөврийн компьютер, хувилагч, зургийн аппарат/ тоног төхөөрөмж худалдан авахад 43.7 сая төгрөг, төр, төсвийн байгууллагуудад эд хогшил, тоног төхөөрөмж, урсгал засварт 129.2 сая төгрөгийг олгосон;
- **Дорноговь** аймгийн Мандах сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хогийн цэг хашаажуулах” ажлын төсөвт захиалагчийн хяналтын зардалд 392.1 мянган төгрөг, “Эрүүл мэндийн төвийн засвар”-ын ажлын төсөвт

³⁸ орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ;

³⁹ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх;

⁴⁰ “Аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх”;

⁴¹ Орон нутгийн төсвийн бус байгууллагад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх;

⁴² ОНХС-ийн хөрөнгийн буцалтгүй тусламж, дэмжлэгт зарцуулахгүй байх.



- 239.8 мянган төгрөгийг тусгасан байна. Гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг бүрэн хянаагүйгээс нийт 631.9 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн, Иххэт сум “Сумын төвийн ундны усны нөөц тогтоох” ажлын төсөвт захиалагчийн хяналтын зардалд 437.7 мянган төгрөгийн тусгасан байтал гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг хянаагүйгээс дээрх дүнгээр санхүүжилтийг илүү олгосон, Айраг сум “Сумын төвд худаг гаргах” ажлын төсөвт захиалагчийн хяналтын зардалд 389.2 мянган төгрөгийн тусгасан байтал гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг хянаагүйгээс дээрх дүнгээр санхүүжилтийг илүү олгосон, Дэлгэрэх сум “Мал угаалгын ванн” барих ажлын гэрээний дүнгээс 33.2 мянган төгрөгийг үндэслэлгүйгээр илүү шилжүүлсэн;
- **Дорнод** аймгийн Булган сумын ОНХС-гийн хөрөнгөөр “Хашаажуулах төсөл” ажлаар сумын айл өрхүүдэд нийт 10.0 сая төгрөгийн хашааг үнэ төлбөргүй олгосон, Хөлөнбуйр сум орон сууцны барилга байгууламж хувь хүмүүст эргэн төлөх нөхцөлөөр олгосноос хугацаа хэтэрсэн, төлөгдөөгүй зээлийн 44.9 сая төгрөгийн үлдэгдэл байна. Мөн сумын ИТХ-аар батлагдсан ОНХС-гийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд тусгагдан батлаагүй, ирээдийн саналыг аваагүй ажилд нийт 3.3 сая төгрөгийг зарцуулсан, Баяндун сум 3.0 сая төгрөгийн төсөвтэй “Халуун усны засвар”-ын ажлын төсвөөс 1.5 сая төгрөгийг батлагдсан арга хэмжээнд зарцуулалгүй Наранбулаг хөгжил ОНӨААТҮГ-ын урьд оны өрийг төлсөн;
 - **Завхан** аймгийн сумууд 2018 онд нийт 38 төсөл, арга хэмжээнд 105.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
 - **Нийслэлийн** ОНХС-аас БГД, БЗД-ийн орон сууцны цахилгаан шатны засварын 2 багц ажилд 475.1 сая, зорилтот бүлгийн айл өрхийг дэвшилтэт технологи бүхий цахилгаан халаагуураар хангах ажилд 97.5 сая, “Туушин” зочид буудлын өмнөх ханыг буулгах, тээвэрлэх ажилд 7.2 сая, СХД-ийн ОНХС-аас Хүй долоон худагт барих ёслол хүндэтгэлийн гэр худалдаж авахад 26.2 сая, улсын баяр наадмын зардал нэрээр зочид төлөөлөгч, ирээдэд хүндэтгэл үзүүлэхээр хүлээн авалт, хоолны зардалд 12.8 сая, ХУД-ийн ОНХС-аас хашаа жигдрүүлж будахад 6.6 сая төгрөг олгох зэргээр зориулалт бусаар зарцуулсан, БНД-ийн ОНХС-аас ЗДТГ-т архивын тавиур худалдан авахад 5.0 сая, Боловсролын хэлтэст тестийн машин худалдан авахад 3.5 сая төгрөг зарцуулсан;
 - **Сүхбаатар** аймгийн ОНХС-аас төв суурин газрын ундны усны үнийн зөрүүг нөхөн төлөхөд 77.2 сая төгрөг зарцуулсан, Баруун-Урт сумын Сүхбаатар тохижилт үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг 30.0 сая, СӨХ-ны үйл ажиллагааны дэмжлэг 10.0 сая, багуудын өдөрлөг зохион байгуулахад 10.0 сая, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд 5.0 сая төгрөг зарцуулсан, Дарьганга сум аймгийн спортын бага наадам зохион байгуулагдахтай холбоотойгоор тэмцээнд оролцох баг тамирчдын хувцас, хэрэгсэл худалдан авахад 3.1 сая төгрөгийг зарцуулсан;
 - **Сэлэнгэ** аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн удирдлагын хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зориулалт бусаар нийт 57.1 сая төгрөгийг зарцуулсан. Тодруулбал: ОНХС-ийн хөрөнгөөр газар зохион байгуулалтын мэдээллийг өгөх ухаалаг самбар авахад 10.0 сая, ухаалаг гар утасны аппликейшн авахад 9.9 сая, Ерөө сум, Бугант тосгоны цагдаагийн хэсэгт автомашин худалдан авахад 18.0 сая, Зүүнбүрэн сум тоглоомын талбайн сагсны самбар солиход 1.0 сая, гудамжны гэрэлтүүлгийн засварт 0.5 сая, хог түрэх тракторын шатахуунд 0.3 сая төгрөг зэрэг нийт 1.8 сая төгрөг, Сант сум нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлгийн цахилгааны зардалд 2.2 сая төгрөг, Орхон сум нийтийн халуун усны газрын цахилгааны зардалд 3.2 сая төгрөг, Орхонтуул сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны ажилтнуудын ажлын байрны тавилга, тоног төхөөрөмж худалдан авахад 5.0 сая төгрөг, ЗДТГ-ын бичиг хэрэг, 2, 3-р БЗД, ХАА-н тасгийн албан хэрэгцээнд компьютер худалдан авахад 6.0 сая, ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ-т хувилагч машин худалдан авахад 1.0 сая төгрөг зэрэг нийт 12.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
 - **Төв** аймгийн Сэргэлэн сумын ИТХ-ын 2018 оны 8/38 тоот “Сум хөгжүүлэх сангийн зээлийн хэмжээ, ОНХС-гийн 2018 онд хийх ажил арга хэмжээнд өөрчлөлт оруулж жагсаалт батлах” тухай тогтоолын хавсралтаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр батлагдсан 4 айлын орон сууцны үлдэгдэл 6.8 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлсэн, Баяндэлгэр сум Сумын ИТХ-ын 2017 оны 04, 2018 оны 28 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хийх төсөл арга хэмжээнд батлагдаагүй ковш худалдан авахад 3.7 сая төгрөг зарцуулсан, Сүмбэр сумын ИТХ-ын 2017 оны 04-р тогтоолын хавсралтаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр баталсан багийн ЗД-ын мотоциклийн үнэ 2.0 сая төгрөгийг ОНХС-аас зарцуулсан, Лүн сум ОНХС-ийн хөрөнгөнөөс 2.1 сая төгрөгийг дотоод удирдлага мэдээллийн системийн төлбөр болон холбооны ярианы төлбөр, шуудангийн төлбөр зэрэг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнд батлагдаагүй зардалд зарцуулсан, Бүрэн сумын ИТХ-ын 2017 оны 04 тоот



тогтоолоор баталсан ОНХС-аар хийх төсөл арга хэмжээнд гэрэлтүүлэг /суурь зарлага/ гэж батлагдсан мөнгөнөөс ЗДТГ-ын шар тракторын сэлбэг 0.6 сая төгрөгөөр авсан;

- **Хөвсгөл** аймагт ОНХС-аас 537.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- **Хэнтий** аймгийн ОНХС-ийн хөрөнгийн 19.0%-ийг удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардал, орон нутгийн өмчийн бус байгууллагад хөрөнгө зарцуулах, буцалтгүй тэтгэмж олгох зэрэгт нийт 331.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Мөн зарим сумдад хөгжлийн дунд хугацааны бодлого байхгүйгээс ОНХС-ийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, ойрын хэрэгцээ шаардлагыг хангахаар журам, заавар зөрчсөн ажлыг ИТХ-аар батлуулж байгаа нь зориулалт бус зарцуулалт хийх үндэслэлийг бий болгож байна.

Цаашид аймаг, сумын орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэйгөө уялдуулан томоохон, хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нийт 2,140.9 сая төгрөгийн зөрчил гаргасныг илрүүлж холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 184.3 сая төгрөгийн 27 төлбөрийн акт тогтоож, 1,528.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах 44 албан шаардлага, 427.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг тус тус хүргүүлсэн. /Хавсралт 4/

В) ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу орон нутгийн өмчид бүртгээгүй байна.

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэл тайланд тусгахгүй орхигдуулдаг зөрчил өмнөх онуудтай харьцуулахад энэ онд багассан боловч зарим аймгууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁴³, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2⁴⁴ дахь хэсэг, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6⁴⁵ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтан гаргасан байна. Тухайлбал:

- **Архангай** аймагт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 27.9 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгаагүй;
- **Баян-Өлгий** аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 783,8 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгээгүй;
- **Баянхонгор** аймагт 2013 оноос хойш ОНХС-ийн хөрөнгөөр малжуулах арга хэмжээнд 685.1 сая төгрөгийн зарцуулснаас 307.5 сая төгрөгийг бүртгэлд тайланд тусгаагүй;
- **Говь-Алтай** аймгийн Алтай сумд 12.0 сая төгрөгийн “Жи мобайл” сүлжээний өргөтгөл, Бигэр сумд 10.0 сая төгрөгийн өвс тэжээл, Дарив сумд 10.0 сая төгрөгийн 0.4-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам, Чандмань сумд 15.4 сая төгрөгийн шилэн кабель, Цээл сумд 63.5 сая төгрөгийн “Сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, аймгийн ОНХС-аас 94.6 сая төгрөгийн хяналтын камер, 50.0 сая төгрөгийн хогийн бункер, 89.0 сая төгрөгийн 2 тарифт цахилгаан тоолуур зэрэг нийт 344.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй;
- **Говьсүмбэр** аймаг данс бүртгэлд тусгуулах жагсаалт гаргахдаа зарим ажлыг давхардуулж зарим ажлыг орхигдуулсан мөн Нийтийн эзэмшлийн орон сууцуудын гадна дулаалга, фасадын ажил нийт 159.9 сая төгрөгийн ажлыг данс бүртгэлд тусгаагүй;
- **Дорноговь** аймаг 111.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгээгүй байна. Мөн Сайншанд сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж гүйцэтгэсэн дараах ТАХ-ыг НББ-д тусгаагүй байна. Үүнд: 8.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Нийтийн бие засах газрыг цэвэр бохир усны шугамд холбох”, 18.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сайншанд сумын 1-р баг 32, 33-р байрны гадна талбайн тохижилт”, 12.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “5-р багт сагсан бөмбөгийн талбай барих”, 10.0 сая төгрөгийн төсөвт

⁴³ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...

⁴⁴ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

⁴⁵ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ



- өртөг бүхий “Нийтийн эзэмшлийн зам талбайд дэгээтэй бункер нийлүүлэх”, 9.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Нийтийн эзэмшлийн зам талбайд жижиг хогийн сав нийлүүлэх”, 40.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сайншанд сумын 3-р багт тоглоомын талбай байгуулах”, 12.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сайншанд сумын 5-р багт сагсан бөмбөгийн талбай барих ажил” зэрэг ажлуудыг бүртгэлд тусгаагүй;
- **Нийслэлд** 134 төсөл, арга хэмжээний 4,990.2 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Үнийн дүнгээр авч үзвэл нийт бүртгэгдэх хөрөнгийн 57.3%, төсөл арга хэмжээний тоогоор авч үзвэл 54.0% нь орон нутгийн өмчид бүртгэгдээгүй байна;
 - **Сүхбаатар** аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр Дарьганга суманд 45.5 сая төгрөгийн өртөгтэй гудамжны гэрэлтүүлэг, Асгат сум малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор 5.0 сая төгрөгийн өртөгтэй хээлтүүлэгч мал /Баяндэлгэрийн улаан ямааны ухна/ худалдан авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна. Мөн өмнөх оноос шилжин ирсэн “Хөдөөгийн алслагдсан сум, суурин газарт өргөн хэрэглээний сүлжээ байгуулах” төсөл арга хэмжээний дагуу хийж гүйцэтгэсэн 300.0 сая төгрөгийн өртөгтэй барилга, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй, Түмэнцогт суманд шинэ суурьшлын бүсэд баригдсан 43.3 сая төгрөгийн өртөгтэй Цахилгаан дамжуулах агаарын шугамыг данс бүртгэлд тусгаагүй;
 - **Сэлэнгэ** аймагт захиалагч аймгийн ЗДТГ болон ОНӨГ-ын харилцан уялдаагүй ажиллагааны улмаас аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 39.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүдэр сумын Тарвагатай 1-р багт 0.4 Квт-ын шугам татах”, 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүдэр сумын гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэг” зэрэг нийт 79.5 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэлд тусгаагүй;
 - **Төв** аймаг тайлант хугацаанд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулагдсан зарим ажлын гэрээний хугацаа хэтэрсэн, ажлын гүйцэтгэл дутуу, комиссын актаар хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгожээ. Эдгээр 68.6 сая төгрөгийн 6 ажлууд нь данс бүртгэлд тусгаадаагүй, Баянчандмань сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн засварын ажлын нийт 35.9 сая төгрөгийн гэрээт ажлыг 17.4 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн, Цээл сумын ахуй үйлчилгээний барилгын 3.8 сая төгрөгийн зураг, төсвийг барилгын нийт төсөвт өртөгт орж тооцогдоогүй, данс бүртгэлд тусгаагүй, Дэлгэрхаан сум 12.2 сая төгрөгийн 2 хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хийгдсэн САХ-ийн тохижилтын ажлыг 599.9 сая төгрөгийн ажлыг 90.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
 - **Увс** аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 270.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгээгүй;
 - **Хэнтий** аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр худалдан авсан 24.0 сая төгрөгийн үнэтэй ундаа, цэвэр усны сав хийх тоног төхөөрөмж, 2.0 сая төгрөгийн нэхий элдэх төхөөрөмж, 5.8 сая төгрөгийн нэхий боловсруулах багц төхөөрөмж авсан боловч түүнийг ашиглалтыг шийдвэрлээгүй байна.

Аудитаар ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг бүртгэл тайланд тусгаагүй 2,539.1 сая төгрөгийн зөрчилтэй холбогдуулан 12.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,483.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 43.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн. /Хавсралт 4/



БҮЛЭГ 3. ТУХАЙН ШАТНЫ ДОТООД АУДИТЫН НЭГЖЭЭС ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙНХЭЭ ДАГУУ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ИТХ ДЭРГЭДЭЭ ХЯНАЛТЫН ХОРОО БАЙГУУЛАН ХЯНАЛТ ТАВИХ АЖИЛ ЖИГДРЭЭГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад зарим аймгууд хяналт тавьж ажиллаагүй байна.

А) ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад зарим аймгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1⁴⁶, 9.4⁴⁷-д заасны дагуу хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хяналт тавьж, үнэлгээ хийж ажиллахаар зохицуулсан.

Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 228 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” батлагдсанаар дээрх заавар хүчингүй болж тус журмын 9.4⁴⁸-т заасныг баримтлан хяналт тавин ажиллаж байна.

Мөн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина” гэж захиалагчийн эрх үүргийг хуульчилсан байдаг.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлд захиалагчаас болон тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэд Хяналтын хороо байгуулж хяналт тавьсан эсэхийг үзэхэд ихэнх аймгуудын хэрэгжилт хангалтгүй байгаа нь дээрх хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

Хүснэгт 7. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьсан байдал

№	Аймаг, нийслэлийн нэр	ИТХ-ын дэргэд Хяналтын хороо байгуулсан эсэх		Захиалагчийн хяналт тавьж ажилласан эсэх
		Аймгийн ИТХ	Дүүрэг, Сумдын ИТХ	
1	Архангай	Үгүй	12 сум байгуулаагүй	Үгүй
2	Баян-Өлгий	Үгүй	5 сум байгуулаагүй	Үгүй
3	Баянхонгор	Хяналт тавьсан	Хяналт тавьсан	Үгүй

⁴⁶ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

⁴⁷ Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

⁴⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.



4	Булган	Үгүй	4 сум байгуулаагүй	Үгүй
5	Говь-Алтай	Үгүй	10 сум байгуулаагүй	20 арга хэмжээнд хяналт тавиагүй
6	Говьсүмбэр	Хяналт тавьсан	боловч зөрчил илрүүлээгүй	Үгүй
7	Дархан-Уул	Хяналт тавьсан	Хяналт тавьсан	1 арга хэмжээнд хяналт тавьсан
8	Дорноговь	Үгүй	12 сум байгуулаагүй	Үгүй
9	Дорнод	Хяналт тавьсан	6 сум байгуулаагүй	Үгүй
10	Дундговь	Үгүй	10 сум байгуулаагүй	Үгүй
11	Завхан	Үгүй	Үгүй	Үгүй
12	Орхон	Хяналт тавьсан	Хяналт тавьсан	Хяналт тавьсан
13	Өвөрхангай	Хяналт тавьсан	Хяналт тавьсан	Үгүй
14	Өмнөговь	Хяналт тавьсан	Хяналт тавьсан	Үгүй
15	Сүхбаатар	Үгүй	Сумдад байгуулаагүй	Үгүй
16	Сэлэнгэ	Үгүй	9 сум байгуулаагүй	Үгүй
17	Төв	Үгүй	8 сум байгуулаагүй	Үгүй
18	Увс	Хяналт тавьсан	Сумдад байгуулаагүй	Үгүй
19	Ховд	Үгүй	Үгүй	Үгүй
20	Хөвсгөл	Үгүй	13 сум байгуулаагүй	Үгүй
21	Хэнтий	Үгүй	9 сум байгуулаагүй	Үгүй
22	Нийслэл	Үгүй	СБД, НД-ээс бусад 7 дүүрэгт байгуулаагүй	Үгүй

Иймд тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэд Хяналтын хороо байгуулаагүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй аймгуудын ИТХ-ын даргад орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагаас цаашид хууль, журамд заасны дагуу хяналт тавин ажиллах зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Б) ТЕЗ-ийн дотоод аудитын нэгж нь холбогдох журмын дагуу ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хийх хяналт, шалгалт хийгээгүй байна.

ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.2⁴⁹, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-т заасны дагуу тухайн шатны дотоод аудитын нэгжээс хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

Аудитаар ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд тухайн шатны дотоод аудитын нэгжээс хяналт шалгалтыг хийсэн эсэхийг үзэхэд ихэнх аймгуудын хэрэгжилт хангалтгүй байгаа нь дээрх журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь аймгууд 2018 оны арга хэмжээнд аудит хийсэн;
- Булган, Дархан-Уул, Төв, Увс аймгууд 2016-2017 оны арга хэмжээнд аудит хийсэн бөгөөд 2018 оны арга хэмжээнд аудит хийгдээгүй;
- Баянхонгор аймаг 2018 оны арга хэмжээнд 2019 оны 05 дугаар сараас хийхээр төлөвлөсөн бол Говьсүмбэр, Хөвсгөл аймгууд 2018 оны арга хэмжээнд аудит хийгдэж байгаа;
- Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, аймгуудын дотоод аудитын албанаас хяналт шалгалт огт хийгдээгүй;
- Ховд аймаг 1 суманд шалгалт хийгдсэн бол Нийслэлийн хувьд Налайх дүүргээс бусад дүүргүүдэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дээрх зөрчил өмнөх аудит болон энэ удаагийн аудитаар давтагдан гарч байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10⁵⁰, 69 дүгээр зүйлийн

⁴⁹ ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ.

⁵⁰ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.



69.1⁵¹ дэх хэсэгт заасан ТЕЗ-ийн дотоод аудитын нэгж нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Иймд тухайн шатны дотоод аудитын нэгжээс холбогдох журмын дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлж цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмжийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн.

В) Орон нутгийн түвшинд ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилт, үр дүнг олон улсын сайн жишээнд харьцуулж үнэлэх ажил хийгдээгүй байна.

Тухайн шатны орон нутгийн дотоод аудитын нэгжээс холбогдох хууль, журмын дагуу хяналт шалгалтын ажил хангалтгүй хийгдсэнтэй холбоотойгоор үр дүнг олон улсын сайн жишээнд харьцуулж үнэлэх ажил хийгдээгүй, энэ талаар тодорхой ойлголтгүй байна.

Нийслэлийн ЗДТГ нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Азийн сантай хамтран хотын засаглалыг сайжруулах төслийг нийслэлд хэрэгжүүлж, төслийн хүрээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнд иргэдээс санал авах ажлыг хялбаршуулахын тулд ухаалаг гар утасны “Smart UB” аппликейшныг хэрэглээнд нэвтрүүлэхээр нийслэлийн 9 дүүргийн 19 хороонд туршилтыг идэвхжүүлэх, нэвтрүүлэх ажлыг 2019 оноос эхлүүлсэн байна.

Гэвч “Smart UB” аппликейшныг ашиглан иргэдийн саналыг цахимаар авах ажлыг туршиж үзсэн боловч үр дүн хангалтгүй гарсан байна.

Цаашид аппликейшн ашиглахад нөлөөлөх интернэт орчин, иргэдийн гар утасны хэрэглээ, хороодын ажилтны мэдлэг чадвар зэргийг анхаарч үнэлэлт, дүгнэлт өгсний дараа иргэдийн саналыг цахимаар авах эсэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

3.2. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг зарим аймгууд холбогдох журам, зааврын дагуу тайлагнаж хүргүүлээгүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1-т “Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор ... аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс хүргүүлнэ ...” гэж заасны дагуу дараах аймгийн сумууд 2018 оны хагас жилийн хэрэгжилтийн тайлангаа хүргүүлээгүй зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Баяннуур, Буянт, Дэлүүн сумууд хугацаандаа хүргүүлээгүй;
- Говь-Алтай аймгийн Алтай, Баян-Уул, Бигэр, Хөхморьт, Цогт, Тонхил, Чандмань сумууд;
- Завхан аймгийн бүх сумууд;
- Сүхбаатар аймгийн бүх сумууд;
- Ховд аймгийн бүх сумууд тус тус тайланг хүргүүлээгүй.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2⁵²-д заасны дагуу 2018 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бүтэн жилийн тайланг 02 дугаар сарын 01-ний

⁵¹ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

⁵² Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.



дотор сумдаас аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т ирүүлэхээр заасан байхад дараах сумууд хүргүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Архангай аймаг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс сумдын хэрэгжилтийн мэдээг албан тоотоор удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй тул хариуцлага тооцох албан шаардлага өгсөн;
- Баян-Өлгий аймгийн Баяннуур сум;
- Говь-Алтай аймгийн Бигэр, Тонхил, Цогт, Чандмань сумууд;
- Завхан аймгийн бүх сумууд;
- Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум хугацаа хоцорсон;
- Сүхбаатар аймгийн бүх сумууд;
- Сэлэнгэ аймгийн бүх сумууд;
- Төв аймгийн бүх сумууд хугацаа хоцорсон;
- Ховд аймгийн бүх сумууд;
- Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дадал, Өмнөдэлгэр, Норовлин сумууд;
- Сүхбаатар дүүрэг, Багахангай дүүргүүд тус тус тайланг хүргүүлж ажиллаагүй.

Мөн журмын 9.3⁵³-т Аймаг, нийслэлийн ХОХБТХ нь ОНХС-ын хэрэгжилтийн тайланг гарган, дүгнэлт өгч, санал боловсруулан тухайн шатны Засаг даргад танилцуулан шийдвэр гаргуулахаар заасан байхад Архангай, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Завхан, Сүхбаатар, Ховд, Хэнтий аймгууд журмын хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.

Уг дүгнэлт болон Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлж байхаар дээрх журмын 9.7⁵⁴-д заасныг Архангай, Дорноговь, Дундговь, Завхан, Сүхбаатар, Ховд, Хэнтий аймгууд мөн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймаг, нийслэлийн ХОХБТХ нь ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус журмын 9.9⁵⁵-д заасны дагуу хүргүүлэхээр заасныг Архангай, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Төв, Ховд аймгууд хүргүүлээгүй бол Орхон аймаг хугацаа хоцорч хүргүүлсэн зөрчил гарсан байна.

Мөн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналыг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд бүртгэж, сангийн хөрөнгийн зарцуулалтад дүн шинжилгээ хийж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах шаардлагатай байна.

Холбогдох журмын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг холбогдох газарт тогтоосон хугацаанд хүргүүлээгүй, тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлээгүй зөрчилд Архангай аймаг хариуцлага тооцох албан шаардлага өгсөн бөгөөд бусад аймгуудад зөвлөмж хүргүүлж ажилласан.

3.3. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

⁵³ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

⁵⁴ Энэ журмын 9.3-т заасан дүгнэлт, Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийн хамт хэлэлцүүлнэ.

⁵⁵ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана...



Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалтад 2018 онд гүйцэтгэсэн аудитын тайланг тус оны 12 дугаар сард баталгаажсан тул холбогдох байгууллагуудад хүргүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.


Өмнөх аудитаар илэрсэн нийт зөрчил, зөрчилд холбогдсон албан тушаалтнуудын мэдээллийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.13⁵⁶-т заасны дагуу “*зохих хууль журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаар хариуцлага тооцуулж хариу ирүүлэх тухай*” албан тоот 2019 оны 02 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн.

Үүний дагуу ЗГХЭГ-аас Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт аудитаар хүргүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчил гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар чиглэл хүргүүлсэн бөгөөд орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагаас Баян-Өлгий аймгаас 3, Ховд аймгаас 2, Хөвсгөл аймгаас 3 буюу нийт 8 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж ажилласан байна.

ОНХС-ийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар нийт 23,695.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд 342.8 сая төгрөгийн 65 төлбөрийн акт тогтоож, 18,290.8 сая төгрөгийн 475 зөрчлийг арилгуулах албан шаардлага, 5,061.8 сая төгрөгийн зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. /Хавсралт 4/

Мөн УАГ-аас ОНХС-ийн 2013-2018 оны хөрөнгийн зарцуулалтад 2013 оноос хойш жил бүр аудит хийсэн бөгөөд хөрөнгийн эх үүсвэр, илэрсэн зөрчлийн харьцааг графикаар, он тус бүрээр харуулбал:

График 2. ОНХС-ийн 2013-2018 оны хөрөнгийн эх үүсвэр, аудитаар илэрсэн зөрчлийн харьцуулалт



Өмнө хийгдсэн аудитын дүнгээс үзэхэд ОНХС-ийн эх үүсвэр 2018 онд 15,833.8 сая төгрөгөөр өссөн боловч нийт зөрчлийн дүн 9,174.8 сая төгрөгөөр буурсан байна. Аудитаар илэрсэн зөрчлийг ангилж хүснэгтээр харуулбал:

⁵⁶ 15.1.13.төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан уг асуудлыг зохих журмын дагуу хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа Үндэсний аудитын газарт ажлын 10 хоногийн дотор мэдэгдэнэ;



Хүснэгт 8. ОНХС-ийн 2013-2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн
аудитаар илэрсэн зөрчил

/тэрбум төгрөг/

Илэрсэн зөрчлийн төрөл	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Тухайн оны нийт төсөвт өртөг	197.3	227.6	149.2	154.2	107.5	123.3
Төсөвт өртгөөс илүү санхүүжүүлсэн	0.8	1.2	0.7	0.3	0.1	0.1
ТЭЗҮ, зураг төсөвгүй, захиалагчийн хяналт тавиагүй болон бусад	0.6	12.3	7.3	15.6	12.1	9.6
Бүртгэл тайланд тусгаагүй	4.7	24.5	10.5	7.7	4.6	2.5
Дутуу, чанаргүй, хугацаа хэтэрсэн	12.8	15.6	3.8	3.3	5.6	3.0
ХАА-ны журам зөрчсөн	10.3	9.2	6.7	2.0	2.8	2.7
Иргэдийн саналаар дэмжигдээгүй	3.7	15.8	13.4	5.0	5.9	3.7
Зориулалт бусаар зарцуулсан	13.3	8.6	5.4	4.1	1.6	2.1
Нийт зөрчлийн дүн	46.2	87.2	47.9	38.0	32.8	23.7
Тухайн оны нийт төсөвт өртөгт зөрчлийн эзлэх хувь	23.4%	38.3%	32.1%	24.6%	30.5%	19.2%

Хүснэгтээс үзэхэд дээрх зөрчил жил бүр гарч байгаа бөгөөд Төрийн аудитын байгууллагаас давтан аудит хийсний үр дүнд зөрчлийн хэмжээ тодорхой хэмжээгээр буурч байгаа нь харагдаж байна.



Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2019.05.21 № 4-1/3226
танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР С.ЭНХБААТАР ТАНАА

Санал хүргүүлэх тухай

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.


Тус аудитын тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй бөгөөд аудитын дүгнэлтэд “Орон нутгийн хөгжлийн сан /цаашид “ОНХС” гэх/-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаарх иргэдийн ойлголт дутмаг, идэвх оролцоо хангалтгүй, ОНХС-тай холбоотой бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны зүгээс тус сангийн мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, тайлагнах, танилцуулах, ил тод байлгах арга хэмжээ дутмаг байна.” гэж тусгагдсантай холбоотойгоор дараах мэдээллийг хүргүүлж байна.

Сангийн яам, Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд иргэд, олон нийтийг ОНХС-ийн хөрөнгийн талаар мэдээ, мэдээллээр хангах зорилгоор тодорхой ажлыг үе шаттайгаар хийж, хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал,

- ОНХС-ийн цахим хуудсыг нээн ажиллуулж, ОНХС-тай холбоотой хууль, журам, зохицуулалт, шинэлэг ажил, иргэдэд чиглэсэн мэдээллийг тогтмол байршуулж байна.
- Сумдын иргэдэд зориулсан сумын төсвийн орлого, зарлага, ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, иргэдийн оролцооны талаар мэдээлэл өгөх зурагт хуудсыг боловсруулж, сумдад хүргүүлэв.
- Аймгийн төслийн ажилтнуудтай хамтран ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Шинэлэг санаачилгын дэд төсөл”-ийг туршилтаар хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрээд байна.

Цаашид иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах зорилгоор ОНХС-ийн танилцуулга, хэвлэмэл материал зэргээр мэдээлэл өгөх бөгөөд, ОНХС-ийн талаар видео танилцуулгыг бэлтгэж, мэдээллийн сувгаар дамжуулан иргэдэд хүргэхэд бэлэн болоод байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ

4476



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Зарим аймгууд ОНХС-ийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрөл тус бүрээр төлөвлөөгүй, зөвхөн ОНХС-ийн орлогын эх үүсвэрээр төлөвлөсөн байна.
2. Аймгийн ОНХС-аас суманд олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд тус тус зөрчсөн байна.
3. Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгаас дүгнэж үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх иргэдийн ойлголт дутмаг, идэвх оролцоо сул, ОНХС-тай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны зүгээс тус сангийн мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, тайлагнах, танилцуулах, ил тод байлгах ажил хангалтгүй байгааг харуулж байна.
4. Зарим аймаг, сум ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн жагсаалтыг гаргаж, тухайн жилийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан боловч урьдчилсан тооцоолол, ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөв батлагдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.
5. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-д заасны дагуу байгуулаагүй байна.
6. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлж буй төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь ажлын гүйцэтгэл чанарт байнгын хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.
7. ОНХС-ийн хөрөнгийг нийгэм, эдийн засагт ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ шаардлагыг хангах зардалд төлөвлөж, зориулалт бусаар зарцуулж байна.
8. Зарим ТЭЗ-ийн дотоод аудитын нэгж нь хяналт шалгалтыг тогтмол тавьж ажиллаагүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, ИТХ-ын дэргэд Хяналтын хороо байгуулаагүй нийтлэг зөрчлүүд байна.
9. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг зарим аймгууд холбогдох журам, зааврын дагуу тайлагнаж хүргүүлээгүй байна.
10. ОНХС-д 2018 онд 123.3 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, зарцуулснаас аудитаар нийт 23,695.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж 342.8 сая төгрөгийн 65 төлбөрийн акт тогтоож, 18,290.8 сая төгрөгийн 475 зөрчлийг арилгуулах албан шаардлага, 5,061.8 сая төгрөгийн зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд тус тус хүргүүллээ.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:

1. Аудитаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах;
2. Өмнөх онуудын аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулж ажиллах;
3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулахдаа ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний биелэлт, үр дүнг тооцох талаар тусгах.

Монгол Улсын Сангийн сайдад:

1. ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналыг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд бүртгэж, сангийн хөрөнгийн зарцуулалтад дүн шинжилгээ хийж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллах.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

1. Аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүрэгт олгох орлогын шилжүүлгийг тооцож хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг тус тус мөрдөн ажиллах;
2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн захирагч нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлан олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн саналыг бодитой тусгах,
3. ОНХС-ийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг иргэдэд тайлагнаж, танилцуулах ажлыг зохион байгуулах;
4. Тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах эрх бүхий иргэн, албан хаагчийг бэлтгэх;
5. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлж буй төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг ажлын гүйцэтгэл, чанарт байнгын хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллах;
6. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын нэгжээс холбогдох хууль тогтоомжийн дагуу ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хяналт шалгалтыг тогтмол хийж байх.



Хүснэгт №1

ОНХС-ийн 2018 оны эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт

/сая.төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-аас олгосон санхүүжилт				Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр										Нийт орлогын дүн
			Батлагдсан дүн /тодотголоор/	шилжүүлсэн	Зөрүү	Ирсэн санхүү- жилтийн хувь	Орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг хасч үлдэх хэсэг		Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр		Дотоод гадаадын хандив, тусламж болон бусад		Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр		Нийт		
							төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	
1	Архангай	252.9	3,597.7	3,597.7	-	100.0			119.4	119.4					119.4	119.4	3,970.0
2	Баян-Өлгий	76.0	4,940.6	4,940.6	-	100.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	5,016.6
3	Баянхонгор	747.4	3,795.7	3,795.7	-	100.0	-	-	60.8	60.8	2,380.3	510.6	1,462.3	1,619.1	3,903.5	2,190.5	6,733.7
4	Булган	438.6	2,312.2	2,312.2	-	100.0	-	-	-	-	-	30.2	-	-	-	30.2	2,781.0
5	Говь-Алтай	224.8	3,399.3	3,399.3		100.0	-				104.1	179.3	-	-	104.1	179.3	3,803.4
6	Говьсүмбэр	675.9	644.6	644.6	-	100.0	-	-	629.0	629.0	-	-	649.7	650.2	1,278.7	1,279.2	2,599.7
7	Дархан-Уул	466.2	2,933.2	2,933.2	-	100.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	3,399.4
8	Дорноговь	188.0	3,275.6	3,275.6	-	100.0	-	-	-	-	-	153.8	170.0	170.0	170.0	323.8	3,787.4
9	Дорнод	401.6	3,650.4	3,650.4		100.0	-	-	-	5.0	576.1	293.2	-	29.7	576.1	327.9	4,379.9
10	Дундговь	566.4	2,075.3	2,075.3	-	100.0	-	-	100.5	83.7	18.4	33.6	-	22.3	118.9	139.6	2,781.2
11	Завхан	169.8	3,471.2	3,471.2	-	100.0	-		-	5.5	-	-	-	48.8	-	54.3	3,695.3
12	Орхон	572.5	3,504.9	3,504.9	-	100.0	-	-	-	-	16.5	-		-	16.5	-	4,077.4
13	Өвөрхангай	145.4	4,374.3	4,374.3	-	100.0	-	-	-	-	-	1,060.6	-	30.8	-	1,091.4	5,611.1
14	Өмнөговь	7,894.7	3,387.6	3,387.6	-	100.0			8,346.7	8,346.7	16.8	16.8			8,363.5	8,363.5	19,645.8
15	Сүхбаатар	483.1	2,666.1	2,666.1	-	100.0	-	-	476.6	228.5	2,817.9	943.2	-	-	3,294.5	1,171.7	4,320.9
16	Сэлэнгэ	255.3	3,838.7	3,838.7		100.0	-	-	-	-	-	12.5	-	-	-	12.5	4,106.5
17	Төв	528.2	3,211.8	3,211.8	-	100.0	-	-	-	-	-	46.6	-	-	-	46.6	3,786.6
18	Увс	97.8	4,227.7	4,227.7	-	100.0	-	-	-	-	-	149.4	-	-	-	149.4	4,474.9
19	Ховд	443.7	4,423.2	4,423.2	-	100.0	-	-	-	-	100.0	599.6	-	-	100.0	599.6	5,466.5
20	Хөвсгөл	195.1	5,455.4	5,455.4	-	100.0	-	-	100.2	100.2	547.8	539.4	-	-	648.0	639.6	6,290.1
21	Хэнтий	196.9	3,110.7	3,110.7	-	100.0	-	-	216.6	157.5	290.2	52.4	443.0	443.0	949.8	652.8	3,960.4
22	Нийслэл	2,340.0	16,258.5	16,258.5	-	100.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	18,598.5
Нийт		17,360.3	88,554.8	88,554.8			-	-	10,049.8	9,736.2	6,868.1	4,621.2	2,725.0	3,013.9	19,642.9	17,371.3	123,286.3



ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд хийгдсэн ажлын сонгон шалгаруулалт

/сая.төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Төлөвлөсөн ажил				ХАА-ны журам								Шууд худалдан авалт	
		Өмнөх оноос шилжсэн		Шинэ оны ажил		НТШ		Хязгаарлагдма л		ХА		ШГБ			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай	15	1,347.6	141	2,125.8	3	373.2	0	-	26	749.0	93	919.2	34	1,432.0
2	Баян-Өлгий	21	441.7	266	4,409.8	18	1,903.6	0	-	39	1,109.2	206	1,297.0	24	541.7
3	Баянхонгор	34	1,637.3	222	6,120.2	21	4,458.5	0	-	44	1,553.1	148	1,095.2	43	650.8
4	Булган	16	152.3	135	1,855.9	15	702.5	2	32.0	30	410.5	85	546.2	19	317.0
5	Говь-Алтай	8	141.3	143	3,464.4	14	904.9	0	-	14	322.6	88	1,388.9	35	989.3
6	Говьсүмбэр	21	565.9	73	2,033.3	3	633.9	0	-	8	267.7	83	1,697.6	-	-
7	Дархан-Уул	0	-	50	2,194.3	6	797.2	0	-	25	965.9	19	431.2	-	-
8	Дорноговь	7	575.5	92	2,761.2	6	1,527.4	0	-	26	674.5	60	559.2	7	575.6
9	Дорнод	2	32.9	201	4,349.8	16	1,232.1	5	58.8	42	920.5	131	2,109.5	9	61.8
10	Дундговь	12	114.0	153	2,342.9	7	700.1	0	-	32	908.4	114	734.4	12	114.0
11	Завхан	14	270.1	362	3,000.7	20	944.6	0	-	2	34.0	148	792.6	206	1,499.6
12	Орхон	4	1,896.3	89	2,190.8	1	160.8	0	-	43	904.3	45	1,125.7	4	1,896.3
13	Өвөрхангай	25	237.4	157	4,374.3	9	1,997.8	-	-	59	1,125.6	87	1,250.9	27	237.4
14	Өмнөговь	27	5,974.1	136	13,288.3	19	14,704.2	3	103.2	35	2,465.2	65	749.9	41	1,239.9
15	Сүхбаатар	23	1,373.5	156	4,832.3	7	860.0	0	-	35	1,088.8	96	1,270.3	41	2,986.7
16	Сэлэнгэ	4	96.2	124	3,535.0	7	1,338.1			58	1,826.5	57	370.4	6	96.2
17	Төв	20	130.9	150	1,472.6	3	142.3	0	-	22	666.6	92	537.5	53	257.1
18	Увс	25	735.9	246	3,162.1	5	1,182.0	0	-	40	768.5	213	1,863.7	13	83.8
19	Ховд	5	338.8	349	4,641.3	15	901.5	0	-	28	258.1	311	3,820.5	-	-
20	Хөвсгөл	17	798.2	262	5,361.7	11	3,049.9	0	-	90	1,264.7	137	959.8	41	885.5
21	Хэнтий	2	54.1	234	3,737.1	4	871.3	0	-	29	706.5	203	2,159.2	-	54.1
22	Нийслэл	4	250.6	419	16,143.4	31	3,786.0	0	-	280	9,863.8	81	1,262.0	31	1,482.2
Нийт		306	17,164.5	4160	97,397.2	241	43,171.8	10	194.0	1007	28,854.0	2562	26,940.9	646	15,401.1



ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Гэрээ байгуулсан ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ				Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ			Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	
		тоо	өртөг /сая.төг/	тоо	Гэрээний дүн /сая.төг/	тоо	Гэрээний дүн /сая.төг/	Үүнээс дутуу олгосон		тоо	Гэрээний дүн /сая.төг/	Олгосон санхүүжи лт /сая.төг/	тоо	өртөг /сая.төг/
								тоо	өртөг /сая.төг/					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Архангай	156	3,473.3	137	3,244.0	128	2,907.9	13	100.9	9	300.3	80.6	19	167.0
2	Баян-Өлгий	287	4,957.8	287	4,844.1	278	4,630.1	69	240.2	6	114.0	65.4	3	100.0
3	Баянхонгор	256	7,757.5	225	6,168.8	190	3,701.6	15	130.4	35	2,458.2	1,563.9	31	1,425.9
4	Булган	151	2,050.7	118	1,681.5	125	1,602.7	5	22.4	9	253.7	129.6	17	150.7
5	Говь-Алтай	151	3,605.7	128	2,652.3	114	2,445.8	1	6.2	14	206.5	199.5	23	848.0
6	Говьсүмбэр	94	2,599.2	92	2,539.0	74	2,143.6	13	46.9	15	395.4	244.9	5	475.2
7	Дархан-Уул	50	2,661.8	50	2,651.3	50	2,651.3	14	210.4		-	-		
8	Дорноговь	92	2,774.9	92	2,756.1	88	2,614.6	12	158.9	4	141.5	123.1	0	-
9	Дорнод	203	4,382.8	186	4,105.3	181	3,904.5	13	79.6	5	210.7	145.2	17	85.8
10	Дундговь	165	2,456.9	145	2,013.3	136	1,832.0	0	143.0	9	202.5	130.4	20	335.0
11	Завхан	376	3,282.2	171	1,819.1	145	1,563.9	2	2.5	20	235.4	209.7	211	1,489.1
12	Орхон	93	4,087.1	93	4,078.4	82	3,605.5	1	14.6	8	414.3	129.6	3	58.6
13	Өвөрхангай	171	4,374.3	155	4,356.3	144	4,190.2	6	6.5	11	159.6	82.7	16	97.8
14	Өмнөговь	163	19,262.5	139	17,571.1	145	11,886.2	17	4,287.6	0	-	-	18	3,090.2
15	Сүхбаатар	179	6,540.3	138	4,135.1	126	3,595.0	6	86.2	12	472.1	383.4	41	227.0
16	Сэлэнгэ	128	3,632.7	125	3,532.9	115	3,414.7	1	101.3	10	118.2	62.3	3	66.4
17	Төв	178	2,933.6	159	2,616.3	145	2,105.9	4	44.4	14	509.2	151.0	19	311.8
18	Увс	270	3,885.0	258	3,784.8	246	2,917.4	4	134.2	12	867.4	835.9	13	83.8
19	Ховд	354	4,980.1	354	4,980.0	303	4,007.7	6		45	972.3	775.6	6	134.1
20	Хөвсгөл	279	10,509.3	228	4,394.2	221	4,370.6	0	-	3	63.5	18.9	55	510.9
21	Хэнтий	236	3,791.2	201	2,814.9	195	2,590.8	10	4.0	6	154.5	122.4	0	-
22	Нийслэл	468	18,285.6	438	17,005.9	363	13,419.6	0	-	25	1,141.5	703.0	80	3,621.3
Нийт		4500	122,284.4	3919	103,744.8	3594	86,101.6	212	5,820.3	272	9,390.8	6,157.2	600	13,278.6
Хувиар					100		83.0				9.1			12.8



/ сая.төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Улсын төсвөөс олгосон нийт санхүүжилт	Нийт илэрсэн зөрчлийн дүн /сая.төг/	Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, акт		Зөрчлийн ангилал																						
						Зориулалт бусаар зарцуулсан		Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн		Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн		Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн		Бүртгэл тайланд тусгаагүй		ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй		төсөвт өртөгөөс илүү санхүү-жүүлсэн		Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй		Хэрэгжээгүй, санхүүжилт аваад ажлаа хийгээгүй		Захиалаг - чийн хяналт тавиагүй		Бусад		
						Төрөл	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай	3,970.0	311.8	Акт			-	-																				
				Албан шаардлага	13	311.8	-	12.6	4	95.3	3	50.4	5	153.5	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-
2	Баян-Өлгий	5,016.6	1,755.8	Зөвлөмж	5		-	-	-																2		3	
				Акт	5	21.9	1	14.5	-	-	-	-	-	-	2	5.5	0	-	2	1.9	-	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	6,733.7	884.5	Албан шаардлага	14	1,733.9	1	59.2	7	692.1	1	63.6	2	100.3	3	818.7	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-
				Зөвлөмж	-	-	-	-	-	-	-	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-
4	Булган	2,781.0	27.3	Акт	2	1.3	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	2	1.3	-	-	-	-	-	-	-	-
				Албан шаардлага	13	822.2	-	-	-	-	-	-	5	448.8	8.0	373.4	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-
5	Говь-Алтай	3,803.4	5,098.1	Зөвлөмж	12	61.0	4	35.7	-	-	1	25.3	1	-	0	-	0	-	0	-	0	-	1	-	5	-		
				Акт	1	4.0	1	4.0	-	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-
6	Говьсүмбэр	2,599.7	603.7	Албан шаардлага	4	5.3	2	4.8	1	0.5	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	1	-
				Зөвлөмж	1	18.0	0	-	0	-	-	-	0	-	0	-	1	18.0	0	-	0	-	0	-	0	-	0	-
7	Дархан-Уул	3,399.4	371.9	Акт	10	35.8	3	8.0	0	-	0	-	0	-	0	-	0	-	1	2.0	0	-	1	3.0	0	-	5	22.8
				Албан шаардлага	220	4,947.4	10	594.1	36	121.2	1	19.0	10	437.2	8	332.7	108	3,101.3	0	-	0	-	10	83.7	24	-	13	258.2
8	Дорноговь	3,787.4	3,427.6	Зөвлөмж	10	114.9	0	-	0	-	-	-	2	114.9	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	8	-
				Акт	0	-	-	-	-	-	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0
9	Дорнод	4,379.9	663.4	Албан шаардлага	6	230.9	0	-	0	-	-	-	5	71.0	1	159.9	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-
				Зөвлөмж	17	372.8	1	70.0	11	236.9	-	-	5	65.9	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-
10	Дундговь	2,781.2	579.6	Акт	1	0.5	0	-	0	-	-	-	1	0.5	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-		
				Албан шаардлага	3	7.4	0	-	0	-	-	-	3	7.4	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-
11	Завхан	3,695.3	1,258.8	Зөвлөмж	2	364.0	0	-	0	-	-	-	2	364.0	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-		
				Акт	4	1.4	4	1.4	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-
12	Орхон	4,077.4	214.0	Албан шаардлага	4	176.8	0	-	0	-	-	-	1	65.2	3	111.6	0	-	0	-	0	-	-	-	0	-		
				Зөвлөмж	8	3,249.4	1	179.0	1	49.2	1	76.4	1	19.9	0	-	2	142.4	0	-	1	21.3	-	-	1	3.0	0	-
13	Өвөрхангай	4,379.9	663.4	Акт	6	123.5	3	58.1	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	3	65.4	0	-		
				Албан шаардлага	7	379.6	1	27.9	0	-	-	-	2	29.5	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	4	322.2
14	Дундговь	2,781.2	579.6	Зөвлөмж	4	160.3	0	-	4	160.3	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-		
				Акт	4	11.1	1	10.0	0	-	-	-	0	-	0	-	0	-	3	1.1	0	-	-	-	-	0	-	
15	Дундговь	2,781.2	579.6	Албан шаардлага	25	568.5	0	-	5	30.6	7	297.6	1	1.8	6	67.7	6	170.7	0	-	0	-	-	-	0	-		
				Зөвлөмж	10	-	1	-	1		1						1				2				4			
16	Завхан	3,695.3	1,258.8	Акт	3	6.9	1	2.6	0	-	-	-	0	-	0	-	0	-	1	1.3	0	-	1	3.0	0	-		
				Албан шаардлага	14	1,123.8	9	672.1	0	-	-	-	4	226.8	0	5.0	0	29.0	0	2.9	0	-	-	-	1	188.0		
17	Орхон	4,077.4	214.0	Зөвлөмж	9	128.1	4	25.8	0	-	1	35.0	0	21.2	0	-	2	5.5	0	-	0	-	-	-	2	40.6		
				Акт																								
18	Орхон	4,077.4	214.0	Албан шаардлага	5	214.0			1	-			2	191.0												2	23.0	
				Зөвлөмж	10	-											1	-									9	-
19				Акт	0	-	0	-	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-		

13	Өвөрхангай	5,611.1	224.7	Албан шаардлага	8		4	18.8	0	-	-	-	4	162.9	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-		
				Зөвлөмж	4		0	-	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	-	4	43.0			
14	Өмнөговь	19,645.8	308.5	Акт	0		0	-	0	-	-	-						0	-	0	-	0	-	0	-			
				Албан шаардлага	5	308.5	1	0.6	0	-	1	5.8						0	-	0	-	0	-	3	302.1			
				Зөвлөмж	1	-	1	-	0	-	-	-						0	-	0	-	0	-	0	-			
15	Сүхбаатар	4,320.9	704.9	Акт	3	7.3	0	-	0	-	-	-	1	5.0	0	-	0	-	0	-	0	-	1	1.2	1	1.1		
				Албан шаардлага	19	527.2	2	18.1	2	16.7	3	159.7	4	77.3	2	50.5	2	110.0	2	44.9	2	50.0	-	-	0	-		
				Зөвлөмж	4	170.4	2	117.3	0	-	-	-	1	9.8	1	43.3	0	-	0	-	0	-	-	-	0	-		
16	Сэлэнгэ	4,106.5	2,179.6	Акт				-										0	-	0	-							
				Албан шаардлага	38	2,179.6	2	57.1	2	778.8	2	154.1			0	79.5	5	617.9					-	8.0	1	176.9	26	307.3
				Зөвлөмж	15			-										0	-	0	-					15		
17	Төв	3,786.6	459.1	Акт	15	30.1	6	16.0	0	-	-	-	0	-	0	-	1	0.6	8	13.5	0	-	-	-	0	-		
				Албан шаардлага	14	429.0	0	-	0	-	-	-	6	205.4	5	135.5	0	-	0	-	1	65.5	2	22.6	0	-		
				Зөвлөмж	3	-	0	-	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-	3	
18	Увс	4,474.9	435.9	Акт	2	7.0	1	-	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	1	7.0	0	-		
				Албан шаардлага	29	428.9	6	41.0	1	45.0	2	31.0	6	41.7	14	270.2	0	-	0	-	0	-	-	-	0	-		
				Зөвлөмж	5																					5		
19	Ховд	5,466.5	2,585.1	Акт	4	50.0	4	50.0	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-		
				Албан шаардлага	8	2,155.2	0	-	2	1,442.8	1	38.0	2	126.1	0	-	2	488.4	0	-	0	-	1	59.9	0	-		
				Зөвлөмж	7	379.9	0	-	0	-	6	359.0	0	-	0	-	0	-	0	-	0	-	1	20.9	0	-		
20	Хөвсгөл	6,290.1	21.9	Акт	0	-	0	-	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-		
				Албан шаардлага	9	21.9	5	15.9	1	-	-	-	2	6.0	0	-	1	-	0	-	0	-	-	-	0	-		
				Зөвлөмж	17	-	0	-	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-	17	
21	Хэнтий	3,960.4	105.7	Акт	3	20.8	2	19.7	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-	1	1.1
				Албан шаардлага	6	84.9	1	6.6	0	-	-	-	0	-	4	78.3	0	-	0	-	0	-	-	-	0	-	1	-
				Зөвлөмж	6	-	0	-	0	-	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	-	0	-	6	
22	Нийслэл	18,598.5	1,473.4	Акт	2	21.1							0	5.3	1	7.3								1	8.5			
				Албан шаардлага	11	1,452.3					1	1,430.4	1	21.9			8								1			
				Зөвлөмж	8			1		1					1		2								3			
Нийт		123,286.3	23,695.4	Акт	65	342.8	27	184.3	-	-	-	-	2	10.8	3	12.8	1	0.6	17	21.2	-	-	7	79.6	2	9.6	6	23.9
				Албан шаардлага	475	18,290.8	44	1,528.8	62	3,223.0	22	2,249.6	65	2,373.8	54	2,483.0	132	4,517.3	2	47.8	3	115.5	13	174.2	34	989.2	44	588.5
				Зөвлөмж	158	5,061.8	14	427.8	18	446.4	11	495.7	12	595.7	2	43.3	9	165.9	-	-	3	21.3	2	20.9	21	2,844.8	66	-

